



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
<http://www.ub.inspection.gov.mn>

ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ХАНГАГЧ,
АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАХИРГААНД

2018.12.18 № 02-07-095/625
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан шинэ жил бусад баяр ёслолын үеэр Нийслэлийн нутаг дэвсгэр дэх барилга байгууламжуудын ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамж, агаар сэлгэлт, уурын зуухны хэвийн, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөл алдагдахаас урьдчилан сэргийлэх, инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний ажилд Барилгын тухай, Орон сууцны тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Эрчим хүчний тухай хуулиуд, бусад холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор энэхүү зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Барилга байгууламжуудын инженерийн шугам сүлжээнд ээлжит бус үзлэг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь даруй арилгах арга хэмжээ авч, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх,
2. Гадна, доторхи шугам сүлжээний засвар үйлчилгээнд хүндрэл учруулах нөхцлийг бүрдүүлсэн, хамгаалалтын зурвас зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг авах талаар анхааруулга, сэрэмжлүүлэг, заавар зөвлөгөө хүргүүлэх,
3. Барилга байгууламжуудын гадна шугам сүлжээний зааг эзэмшлийг нарийвчлан тогтоож, эзэмшигч нарт мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгөх,
4. Аваари, гэмтлийн үед засвар үйлчилгээнд хэрэглэгдэх материал, сэлбэг хэрэгсэл /насос, хөдөлгүүр, сэнс, хоолой, гэх мэт/-ийг нормативын дагуу нөөцлөх,
5. Гадна шугам сүлжээний худгуудыг тагтай байнга байлгах,
6. Худаг доторхи хог хаягдлыг цэвэрлэх, хаалт арматуруудын ус алдалтыг засварлах, хоолойн дулаалгыг сайжруулах,

115050004629

7. Ус, дулаан дамжуулах төв, зангилааны нөөц насосуудыг хэвийн ажиллагаатай байлгах,

8. Ажлын байрын эмх цэгц, ариун цэвэр, тохижилт, гэрэлтүүлгийг сайжруулах,

9. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны 3-н шатны зааварчилгааг тогтмолжуулах, нэн ялангуяа өдөр тутмын зааварчилгааг ажлын онцлог, орчин нөхцөлд нь тохируулж, тухай бүр өгч баталгаажуулж байх,

10. Ажилчдын өвлийн ажлын хувцас, багаж хэрэгслийг бүрэн олгох,

11. Ажил, мэргэжлийн аюулгүй ажиллагааны заавар, барилга байгууламжийн схем зургийг ажлын байранд байрлуулах,

12. Ус, дулааны зангилааны тоног төхөөрөмж, шугам хоолойнуудад хаягжилт, тэмдэг тэмдэглээ тавих,

13. Барилга байгууламжуудын зураг төсөл, бичиг баримтыг иж бүрдүүлж, эмх цэгцтэй хадгалах, параметрийн мэдээний болон дуудлага хүлээн авах дэвтрийг үнэн зөв хөтлөх, төлбөрт үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх,

14. Ус, дулаан хангамжийн системийн хангагч, ашиглагч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, баяр ёслолын үеэр хариуцлагатай эргүүл жижүүр гаргах,

15. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.

- Хувийг:** 1. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т
2. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨҮГ-т
3. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д
4. Хэсэгчилсэн инженерийн байгууламжийн удирдах газар ОНӨҮГ-т
5. ОСА-ын хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л.БАТБАЯР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  З.ОЧИРПҮРЭВ